



## “АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.04.01

№ ТУЗ2014005

Улаанбаатар хот

### ТУЗ-ИЙН ДАРГЫГ ЧӨЛӨӨЛЖ, ШИНЭЭР ТОМИЛОХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 4 сарын 1-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 78.1 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн ТУЗ-ийн дарга С.Балжиннямын өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн ТУЗ-ийн даргын үүрэгт ажлаас нь 2014 оны 4 сарын 1-ний өдөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

**ХОЁР.** Алтай зам ХК-ийн ТУЗ-ийн нийт гишүүдийн 100 хувийн саналыг авсан М.Нямдавааг 2014 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн даргаар сонгогдсоныг батласугай.

**ГУРАВ.** М.Нямдаваад компанийн тухай хууль болон Дүрэмд заасан бүрэн эрхийг олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА



## “АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014.04.01

№ ТУЗ2014006

Улаанбаатар хот

### ТУЗ-ИЙН ДЭД ХОРООДЫГ БАЙГУУЛАН ДАРГА, ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 4 сарын 1-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 76.1.18; 81.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

**НЭГ.** Алтайн Зам ХК-ийн ТУЗ нь дэргэдээ дараахи хороодтой байхаар тогтоосугай..

- Аудитын хороо
- Нэр дэвшүүлэх хороо
- Цалин урамшууллын хороо

**ХОЁР.** Дэд хороодын дарга болон гишүүдийг дараахи бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Аудитын хорооны дарга	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бат-Ирээдүй
Аудитын хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Байлхүү
Аудитын хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн С.Баянмөнх
- Нэр дэвшүүлэх хорооны дарга	ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуун
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн С.Балжинням
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Сономжамц
- Цалин, урамшууллын хорооны дарга	ТУЗ-ийн гишүүн Ц.Ганцэцэг
Цалин, урамшууллын хорооны гишүүн	ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэг
Цалин, урамшууллын хорооны гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бат-Ирээдүй

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА